



## БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 8184

Улаанбаатар хот

“Даатгуулагчийн малчнаар ажиллаж  
нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг  
тодорхойлох орон тооны бус байнгын зөвлөл”-н  
үйл ажиллагааг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын өрөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2024 оны А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Нийгмийн даатгалын өрөнхий хуульд даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэдэх “Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл” шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан тул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус байнгын зөвлөл”-н үйл ажиллагааг зогсоосугай.

2. Орон тооны бус байнгын зөвлөл ажиллаж байх хугацаанд шийдвэрлэсэн хурлын тэмдэглэл, тогтоол бусад холбогдох баримтуудыг Нийгмийн даатгалын газарт хүлээлгэн өгөхийг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус байнгын зөвлөл” байгуулах тухай 2018 оны А/70 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажилзахирамж

1123200092